*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*2 дугаар хавсралт*

*Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн Лавлагаа шатлалын тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Хулангийн*

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| ЗОРИЛТ 1. “ДОНОР, ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ, ХАВДАР, ХӨНГӨВЧЛӨХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ГЕМОДИАЛИЗЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** МУ-ын 2023.05.17-ны тэмдэглэл Донорын цус, цусан бүтээгдэхүүн, сорьц, эд, эрхтнийг улсын хилээр нэвтрүүлэх журмыг боловсруулж, батлуулна. | Засгийн газраар батлагдсан журам-1 | - | Журмын төслийг батлуулсан байна. | - | I-IV улирал | 0% |
| 2. | **Арга хэмжээ 1.2.** Донороос эс, эд, эрхтэн шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Шинэчлэн батлагдсан журам | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А198 дугаар тушаалаар зохицуулагдаж байна. | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А198 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт хийсэн байна. | Донороос эс, эд, эрхтэн шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг боловсруулж, газар, хэлтсийн дарга нараас санал авч байна. | I-IV улирал | 90% |
| 3. | **Арга хэмжээ 1.3.** “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэргэжлийн салбар | Байгуулагдсан мэргэжлийн салбар зөвлөл | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А210 | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А210 дугаар тушаалд | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/433 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэргэжлийн салбар | I-IV улирал | 100% |

ЬФУ

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөл"-ийг байгуулна. | | дугаар тушаал | нэмэлт өөрчлөлт орж, мэргэжлийн салбар зөвлөл байгуулагдсан байна. | зөвлөл" 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан. | | |
| 4. | **Арга хэмжээ 1.4.** Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах ёс зүйн удирдамжыг боловсруулж, батлуулна. | Батлагдсан удирдамж-1 | - | Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах ёс зүйн удирдамжыг боловсруулж, батлуулсан байна. | Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах ёс зүйн удирдамжын төслийг боловсруулж, газрын дарга нараас санал авч байна. | I-IV улирал | 70% |
| 5. | **Арга хэмжээ 1.5.** ЭМСCТ 3.3 Хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг бууруулж, чанар, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө боловсруулж, батлуулна. | Төлөвлөгөөний боловсруулалтын хувь, Батлагдсан төлөвлөгөө-1 | - | Төлөвлөгөөг батлуулсан байна. | 1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өндөр байгаа хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/331 дүгээр тушаалаар "Хавдраас сэргийлэх, хянах" хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/350 дугаар тушаалаар "Зонхилох байрлалын хавдрын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаарх бодлогын санал гаргах, хөтөлбөр боловсруулах" дэд ажлын хэсэг, 2024 оны А/351 дугаар тушаалаар "Ходоод, улаан хоолой, бүдүүн-шулуун гэдэсний хорт хавдар", 2024 оны А/352 дугаар тушаалаар "Уушгины хорт хавдар", 2024 оны А/353 дугаар тушаалаар "Хөхний хорт хавдар", А/354 дугаар тушаалаар "Элэгний хорт хавдар", А/355 дугаар тушаалаар "Умайн хүзүүний хорт хавдар"-ын дэд ажлын хэсгүүд тус тус байгуулагдсан.<br><br>Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд нийт 14 удаа танхимаар хуралдаж, дэд | I-IV улирал | 90% |

195

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлын хэсгүүдээс гарсан саналын дагуу хөтөлбөрийн төсөл, зонхилох байралын хавдраар 6 дэд төлөвлөгөөний төслийг боловсруулж, ЭМЯ-ны УЗХ-аар хэлэлцүүлэхээр гишүүдэд хүргүүлсэн.<br><br>2. Итгэл найдварын туяа төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Олон улсын атомын энергийн агентлагтай 2024.01.31-ний өдөр болон 2024.02.21-ний өдрүүдэд, 2 удаагийн цахим уулзат зохион байгуулж, “Цөмийн анагаах ухаан, туяа эмчилгээний үндэсний чадавхыг сайжруулах замаар хорт хавдрын менежментийг сайжруулах” төслийг саналын дагуу засварлан 2024.02.16-ны өдөр Олон улсын атомын энергийн агентлагт хүргүүлсэн. | | |
| 6. | **Арга хэмжээ 1.6.**<br>ЗГҮАХ 2.1.1.4<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 1.3.1<br>ЭМССТ 1.5 “Хавдрын эсрэг” арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулна. | Хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамралтын хувь | Хэрэгжилт 80 хувьд хүрсэн. | 2024 онд хэрэгжих эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааны хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаалаар батлагдсан “Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө”-ний эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой 22 үйл ажиллагааны хэрэгжилт 81 хувь. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээгээр 1 сая гаруй хүн хамрагдсанаар 5797 сэжигтэй тохиолдол илэрч, хорт хавдартай 304 хүн оношлогдож, хяналтад орсон байна.<br><br>2024-2028 онд хэрэгжүүлэх Эрт илрүүлэг 2.0 ажлын хүрээнд зонхилох байрлалын буюу элэг, ходоод, улаан хоолой, бүдүүн-шулуун гэдэс, уушги, хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэг, оношилгоог үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд баг тус бүр 1 удаа, дэд ажлын хэсгүүд хамтран 8 удаа, нийт 14 удаа танхимаар хуралдаж, эрт илрүүлэг зохион байгуулах алгоритм, шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөц, эдийн засгийн | I-IV улирал | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | судалгааг гаргаж, 2025 оноос Улаанбаатар хотод зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Одоогоор эрт илрүүлгийн зааврын төслийг боловсруулсан ба дүрс оношилгоо, дуран, эмэгтэйчүүдийн хавдрын эрт илрүүлгийн сургалтыг 12 сард зохион байгуулахаар ажиллаж байна. | | |
| 4. | **Арга хэмжээ 1.7.** Олон улсын атомын энергийн агентлаг, Олон улсын хавдар судлалын агентлаг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Монгол Улсад хавдрын хяналтын чиглэлээр цогц үнэлгээ (Impact review) хийх ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээ, цогц үнэлгээний тайлан | - | Монгол Улсад хавдрын хяналтын чиглэлээр цогц үнэлгээ хийгдсэн байна. | 1. Олон улсын атомын энергийн агентлаг, Олон улсын хавдар судлалын агентлаг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Монгол Улсад хавдрын хяналтын чиглэлээр цогц үнэлгээ хийх багийн зохион байгуулалт, ажлын удирдамжийг ЭТҮГ-ын даргаар 2024.03.15-ны өдөр батлуулсан.<br><br>Өөрийн үнэлгээ хийх зорилгоор Олон улсын атомын энергийн агентлагт 2024.02 сараас 05 сарын хооронд дараах баримт бичгийг хүргүүлсэн. Үүнд:<br>- Хавдрын тусламж үйлчилгээний хууль, эрх зүйн орчин, бодлогын баримт бичиг, судалгааны материал,<br>- Өөрийн үнэлгээний 12 асуумж,<br>- УНТЭ, УХТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СХД-ийн эрүүл мэндийн төвийн хавдрын тусламж, үйлчилгээний нөхцөл байдлын мэдээлэл.<br>Өөрийн үнэлгээний мөрөөр олон улсын экспертүүд, үндэсний экспертүүдтэй 20 удаагийн цахим уулзалт зохион байгуулсан.<br>2. Хавдрын хяналтын чиглэлээр цогц үнэлгээ хийх үеийн нарийвчилсан төлөвлөгөөг 2024.04.26-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.<br><br>Төлөвлөгөөний дагуу Олон улсын үнэлгээний баг 2024 оны 05 дугаар сарын 6 наас 10-ны өдрүүдэд Монгол улсад ажиллаж, өрхийн болон дүүргийн эрүүл | I- II улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэндийн байгууллага, Интермед эмнэлэг, Эмгэг судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын нэг, хоёрдугаар төв эмнэлгүүдэд хавдрын тусламж, үйлчилгээний үйл ажиллагааг үнэлсэн. Олон улсын шинжээчид үнэлгээний урьдчилсан дүгнэлт, зөвлөмжийг 2024.05.10-ны өдөр танилцуулсан, 2024.10 сард үнэлгээний урьдчильсан тайлан, зөвлөмж ирсэн ба саналыг хүргүүлсэн. | | |
| ЗОРИЛТ 2. “ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ГАДААД УЛСАД ЭМЧЛҮҮЛЭХЭЭР ИЛГЭЭЖ БАЙГАА ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТЕХНОЛОГИЙГ ЭХ ОРОНДОО НЭВТРҮҮЛЭХ, ЭМЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ИРГЭНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.** Гадаад оронд зайлшгүй шаардлагаар эмчлүүлсэн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зөвлөлийн журам, бүрэлдэхүүн өвчний жагсаалтыг шинэчилнэ. | Батлагдсан журам-1 | Журмын төсөл 50 хувь боловсруулагдсан. | Журмын төслийг эцэслэн боловсруулж, батлуулсан байна. | Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүлийн 19.3.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 7.1.5 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолын 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/273 дугаар тушаалаар “Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”, “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн””, “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”, “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэдэд эмнэлгийн дүгнэлт гаргах маягт”-ыг баталсан. | I-II улирал | 100% |
| 2. | **Арга хэмжээ 2.2.** Гадаад оронд зайлшгүй | - Хурлын тоо | 2023 онд 99 иргэдийн өргөдлийг | Иргэдийн өргөдлийг судлан хурлаар | <u>Гадаад эмчилгээний 1-дүгээр хурал:</u> Шаардлага хангасан 7 иргэний материалыг судалж, зөвлөлийн 2024.01.19-ний хурлаар | I-III улирал | 100% |

88

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлагаар эмчлүүлсэн иргэдийн 2024 онд ирүүлсэн өргөдлийг хүлээн авч, хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэнэ. | - Ирсэн өргөдлийн тоо<br>- Сайдын тушаалын тоо | шийдвэрлэсэн. | хэлэлцүүлж, сайдын тушаалаар шийдвэрлэсэн байна. | хэлэлцүүлж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалаар 75.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн.<br><u>Гадаад эмчилгээний 2-дугаар хурал:</u><br>Шаардлага хангасан 28 иргэний материалыг судалж, зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 2-р хурлаар хэлэлцүүлж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/322 дугаар тушаалаар 753.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.<br><u>Гадаад эмчилгээний 3-дугаар хурал:</u><br>Хурлаар хэлэлцүүлэх 14 иргэний материалыг судалж, гадаад эмчилгээний асуудал хариуцан мэргэжилтэнд 2024.09.17-ны өдөр хүлээлгэн өгсөн.<br>*Хурлын тоо-2*<br>*Өргөдлийн тоо-49*<br>*<u>Сайдын тушаалын тоо-2</u>* | | |
| 3. | **Арга хэмжээ 2.3.**<br>МУХТЖҮЧ 2.2.6, ЗГҮАХ-2.1.3<br>МУХТ 3.3.2.7.<br>Монгол Улсад оношлогдох, эмчлэгдэх боломжгүй өвчний чиглэлээр технологи нэвтрүүлнэ. | - ШУТЗ-өөр хэлэлцүүлсэн төслийн тоо<br>- Хэрэгжүүлж эхэлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | 2017 оны А/370 тушаалаар Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчин эмгэгийн жагсаалтыг баталсан. | - | 1. Шинэ технологийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохоор Лавлагаа шатлалын 6 эрүүл мэндийн байгууллагын 25 төслийг ШУТЗ-өөр хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.<br>2. Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Уг тушаалаар Монгол Улсад эмчлэх боломжгүй онош 26-аас 25 болж буурсан.<br><br>Гадаад эмчилгээний жагсаалтад байсан өвчин эмгэгээс дараах эмчилгээний технологийг нэвтрүүлсэн:<br>1. Дутуу нярайн торлогийн эмгэгийн улмаас торлог ховхрох үеийн торлог шилэнцрийн мэс заслыг бүрэн нэвтрүүлсэн (В6). | I-III улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс заслын 2 заалтаас мөч хадгалах боломжтой үеийн хорт хавдрын нөхөн сэргээх мэс заслыг нэвтрүүлсэн (Д14).<br>3. Сонсголын мэдрэлийн хавдрын үеийн мэс засал эмчилгээг нэвтрүүлсэн ч одоогоор бүрэн нутагшаагүй гэж үзсэн тул хэвээр үлдээсэн (Б3).<br>4. Хүзүү, нурууны нугас тасарсан гэмтлийн үеийн мэс засал (Ё18) ба сээр, бүсэлхий нурууны төрөлхийн муруйлт эмгэгийн мэс заслын эмчилгээ (Ё19)-нээс хөнгөн, дунд хэлбэрийн үеийн мэс заслыг хийж эхэлсэн. Одоогоор “хүнд” хэлбэрийн үед мэс засал хийгдэхгүй байна.<br>5. Бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг нутагшуулсан (Ж22).<br>6. Элэгний вирусийн идэвхжил өндөр, хавдартай бүх тохиолдолд гадаад улсад элэг шилжүүлэн суулгах мэс засалд явуулдаг байсан бол одоо артер, венийн судас болон цөсний замын анатомын хэвийн бус бүтэцтэй, резус факторын үл тохиролтой, 2 донороос суулгахаас бусад тохиолдолд элэг шилжүүлэн суулгах мэс заслыг хийдэг болсон (Ж22). | | |
| ЗОРИЛТ 3. “ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН БУСАД ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН БОЛОН НЭГЖИЙН ДОТООД АЖИЛД ОРОЛЦОХ, УДИРДЛАГААС ХУУЛЬ ЁСНЫ ХҮРЭЭНД ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ БИЕЛҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1.** Түлэгдэлтийн тусламж үйлчилгээний заавар батлуулна. | Батлагдсан заавар-1 | - | Заавар батлагдсан байна. | Журмын төслийг боловсруулсан. | I-IV улирал | 50% |
| 2. | **Арга хэмжээ 3.2.** Люксембургийн Засгийн газрын санхүүжүүлэлтээр хэрэгжүүлж буй | Батлагдсан төлөвлөгөө-1, Үйл ажиллагааны | 2023 оны үйл ажиллагаан ы хэрэгжилт 83%. | - | – Люксембургийн Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй MON007 төсөл, “Хэрэхийн шалтгаант зүрхний өвчнөөс сэргийлэх түүнийг бууруулах төсөл”-ийн 2024 оны үйл ажиллагааны | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | MON007 төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавина. | тайлангийн хэрэгжилт, Батлагдсан дотоодын заавар, үйлдлийн технологийн стандарт-3 | | | төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төслийн удирдах хорооны дарга, Төслийн удирдах хорооны дэд дарга, Төслийн захирал нараар 2024.01.12-ны өдөр батлуулсан.<br>– МОН/007 - 2024 оны хагас жилийн удирдах хорооны хурлыг 2024.09.19-ний өдөр зохион байгуулсан. Төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл 62.8%, санхүүгийн гүйцэтгэл 52.5%.<br>– “Хэрэхийн шалтгаант зүрхний өвчнөөс сэргийлэх түүнийг бууруулах төсөл”- 2024 оны хагас жилийн зөвлөх хорооны хурлыг 2024.09.20-ны өдөр зохион байгуулсан. Төслийн санхүүгийн гүйцэтгэл 57%. | | |
| 2. | **Арга хэмжээ 3.3.** Люксембургийн Засгийн газрын санхүүжүүлэлтээр хэрэгжүүлж буй 3 төслийн нэгдсэн ажлын хэсэг байгуулж, уялдаа холбоог хангаж ажиллана. | Ажлын хэсгийн тушаал-1 | - | Ажлын хэсэг тушаалаар батлагдсан байна. | Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын Зүрх судлал, Зүрхний мэс засал ба Телемедицин” МОН/007, “Хэрхийн шалтгаант зүрхний өвчнөөс сэргийлэх түүнийг бууруулах төсөл” ба “Монгол Улсад Сэргийлэх боломжтой эхийн болон перинаталь эндэгдлийг тэглэх үйл ажиллагааг эрчимжүүлэх нь” төслүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2024.04.19-ний А/185 дугаар ажлын хэсгээр байгуулсан.<br><br>Техникийн ажлын хэсгийн хурлыг 2024.04.25, 2024.09 зохион байгуулсан.<br><br>*Ажлын хэсгийн тушаал-1*<br>*Хурал-2* | I-IV улирал | 100% |
| 3. | **Арга хэмжээ 3.4.** Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн | Өгсөн саналын тоо | - | Санал өгсөн байна. | Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийн журмын төсөлд ТЗУГ-т 2024.08 сард санал өгсөн. | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг батлуулна. | | | | | | |
| 4. | **Арга хэмжээ 3.5.** Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулна. | Өгсөн саналын тоо | - | | Тайлант хугацаанд санал авах төсөл ирээгүй. | I-IV улирал | - |
| ЗОРИЛТ 4. "ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 4.1.** Хүүхдийн хорт хавдрын тусламж үйлчилгээ, хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулна. | Батлагдсан төлөвлөгөө-1, Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | Төлөвлөгөөг батлуулсан байна. | Хүүхдийн хорт хавдрын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Нийт 16 ЭМБ-аас төлөвлөгөөнд тусах саналыг авч нэгтгэсэн. 2024.06.18-нд төлөвлөгөөний эцсийн хэлэлцүүлж, төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөрт 1 бүлэг болж орсон. | I-IV улирал | 80% |
| 2. | **Арга хэмжээ 4.2.** ЗГҮАХ 2.3.2.6 Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2023 оны БШУ, ЭМ, ХНХ-ын сайдын А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалаар зохицуулагдаж байна. | 2024 оны төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжсэн байна. | 2024 онд төлөвлөсөн арга хэмжээний биелэлт 50%. | I-IV улирал | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Арга хэмжээ 4.3.** 1 хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлтийн журмыг шинэчилнэ. | Батлагдсан журам-1 | Журмыг 40% боловсруулсан. | Журмыг боловсруулж, батлуулсан байна. | - | I-IV улирал | 0% |
| 4. | **Арга хэмжээ 4.4.** Хүүхдэд үүдэл эс шилжүүлэн суулгах эмнэлзүйн заавар боловсруулж, батлуулна. | Батлагдсан журам-1 | Журмыг 40% боловсруулсан. | Журмыг боловсруулж, батлуулсан байна. | Журмын төслийг боловсруулсан. | I-IV улирал | 70% |

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | НҮБ-ын Хүүхдийн сангаас хэрэгжүүлж буй Хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөрийн хүрээнд 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлын эмчилгээний хоолыг хуваарилах. | Сайдын тушаал-1 | - | Сайдын тушаалаар зорилтот аймаг, дүүрэгт 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлын эмчилгээний хоолыг орлогод авч, хуваарилсан байна. | НҮБ-ын Хүүхдийн сангаас хэрэгжүүлж буй Хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөрийн хүрээнд зорилтот аймаг, дүүрэгт нийлүүлэгдэх 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлын 33 хайрцаг F75 эмчилгээний сүү, 20 хайрцаг F100 эмчилгээний сүү, 769 хайрцаг RUTF эмчилгээний бэлэн хоолыг ЭМС-ын 2024.02.13-ны өдрийн А/13 дугаар тушаалаар орлогод авч, хуваарилсан. | I-IV улирал | 100% |
| 2. | Хавдрын эмийн хүртээмжийн (АТОМ) | Ажлын хэсгийн тушаал-1, | - | Хавдрын эмийн хүртээмжийн (АТОМ) | Хавдрын эмийн хүртээмжийн (АТОМ) хөтөлбөрийг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | | | хөтөлбөрийн ажлын хэсгийг байгуулж, хэрэгжүүлсэн байна. | журмыг ЭМС-ын 2024.05.09-ний өдрийн А/214 дүгээр тушаалаар байгуулсан.<br>Зохицуулах зөвлөлийн 1 дүгээр хурлыг 2024.05.16-ны өдрийн 09 цагт цахимаар зохион байгуулж, МУ-д үнэлгээ хийх төлөвлөгөөг гаргасан.<br>АТОМ, МАКС хөтөлбөрийн төлөөллүүд 2024.11.25-ны өдрөөс 2024.11.29-ний өдрийн хооронд МУ-д айлчилж, ЭМС болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж, хавдрын эмийн хүртээмж, оношилгооны чадавхид хийсэн үнэлгээний төслийг танилцуулж, сайжруулсан. | | |
| 3. | Хүүхдийг ивээх сантай санамж бичиг байгуулах. | Санамж бичиг-1 | - | Хүүхдийг ивээх сантай санамж бичиг байгуулсан байна. | Япон улсын Гадаад хэргийн яамны Төрийн бус байгууллагад санхүүжилт олгох схемийн санхүүжилттэй "Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийг хэрэгжүүлэхээр Монгол дахь Хүүхдийг ивээх сантай 2024.05.02-ны өдөр Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. | I-II улирал | 100% |
| 4. | "Багийн эмчийн зөвлөгөөн", "Эмч нар VII дугаар Их хурал", "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ий зохион байгуулалтад оролцсон. | Зохион байгуулсан зөвлөгөөн-1 | - | Зөвлөгөөний зохион байгуулалтад оролцсон байна. | "Багийн эмчийн зөвлөгөөн", "Эмч нар VII дугаар Их хурал", "Удирдах ажилтны зөвлөгөөн"-ий зохион байгуулалтад тус тус оролцсон.<br>Мөн Багийн эмч нарын үзлэг, шинжилгээ зохион байгуулах ажилд ХСҮТ-ийг хариуцан ажилласан. | IV улирал | 100% |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.** Англи хэлний ахисан түвшний сургалтад хамрагдаж, төгссөн байна. | Суралцсан кредит цаг | - | 4 кредит | - Австралийн “Queensland” их сургуулийн EDX программын цахим сургалтын хөтөлбөрийн дагуу IELTS-ийн ахисан шатны түвшний бэлтгэл сургалтад 2024.05.28-ны өдрөөс эхлэн цахимаар хамрагдаж байна (2024.12.20-нд дуусна). | I-IV улирал | 100% |
| 2. | **Арга хэмжээ 2.** Хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдсан байна. | Суралцсан цаг, хамрагдсан сургалтын тоо | - | 3 сургалт, 6 цаг | - АШУҮИС-с зохион байгуулсан Эрүүл мэндийн бодлого сургалтад 2024.07.26-ны өдөр оролцсон.<br>- Монголын эдийн засгийн залуучуудын форум 2024-т 2024.07.07-07.08-ны өдрүүдэд оролцсон. | I-IV улирал | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Лавлагаа шатлалын тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн ................................ / Г.Хулан / 2024.12.05